

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нийцлийн аудитын алба



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“БИЧИЛ УУЛ УУРХАЙГААР АШИГТ МАЛТМАЛ ОЛБОРЛОХ ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТ”-Д ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ХОА-2020/06/-НА

Ховд хот
2020 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын захирал бөгөөд
Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар
Утас: 99047408 Цахим хаяг: Boldbaatar.khu@audit.gov.mn
Аудитын менежер: А.Цэцэгсүрэн
Утас: 99013699 Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn
Аудитор: Д.Эрдэнэцэцэг
Утас: 99019943 Цахим хаяг: Erdenetsetseg D@audim.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

Товчилсон үгийн жагсаалт3

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй стандартын талаарх мэдэгдэл.....4

Бүлэг 1. Бичил уул уурхайн талаар засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдсан ажил хэрэгжсэн боловч бичил уурхай эрхлэгчид байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд хамрагдаж менежмент төлөвлөгөө батлуулаагүй байна.....6

1. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт бичил уурхайн чиглэлээр хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй хэрэгжсэн байна.
2. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд хамрагдаж байгаль орчныг хамгаалах менежмент төлөвлөгөө боловсруулан батлуулж хэрэгжилтийг хангаж ажиллаагүй байна.
3. Бичил уул уурхайн ашигт малтмал олборлох журмын дагуу газар нутгийг орон нутгийн тусгай хэрэгцээнд авах ИТХ-ын тогтоол шийдвэр хуулийн хүрээнд хэрэгжсэн байна.

Бүлэг 2: Эвдэрсэн газрыг нөхөн сэргээхэд шаардлагатай зардлыг холбогдох хуулийн дагуу төлөвлөж, төсөвт тусгаагүйгээс эвдэрсэн газруудыг нөхөн сэргээх, орчныг хамгаалах ажлууд хийгдэхгүй байна.....9

1. Бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалыг байгаль орчны асуудал эрхэлсэн байгууллагатай хамтран баталж, хэрэгжилтийг хангаж ажиллаагүй байна.
2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөг бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалын дагуу хийж нөхөн сэргээлтийн зардалд шаардагдах хөрөнгө төвлөрүүлж нөхөн сэргээлт хийсэн баримт байхгүй байна.
3. Нөхөн сэргээлт хийгээгүй болон ашигт малтмал олборлох гэрээний үүргээ биелүүлээгүй бичил уурхай эрхлэгч этгээдтэй хариуцлага тооцоогүй байна.

Бүлэг3. Мэргэжлийн байгууллагуудын хяналт, шалгалтын үйл ажиллагаа үр нөлөөтэй хэрэгжихгүй байгаагаас хууль бус олборлолтоос үүссэн эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, экологи эдийн засгийн үнэлгээ хийгдээгүй байна.....11

1. Байгаль хамгаалах, нөхөн сэргээх, мэдээллийн сан бүрдүүлэх ажил хууль тогтоомжийн дагуу хэрэгжээгүй байна.
2. Хууль бус болон зөвшөөрөлтэй олборлолт хийсэн эвдэрсэн газрын экологи, эдийн засгийн үнэлгээ хийгээгүй, хохирлыг тооцоогүй байна.
3. Мэргэжлийн байгууллагуудын хяналт шалгалтаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

Хууль бус олборлолтоос эвдэрсэн газрын экологи эдийн засгийн үнэлгээ хийж нөхөн төлбөр тооцоогүй байна.

Аудитын дүгнэлт.....16

Аудитын зөвлөмж17

Тэргүүлэх Аудиторын тушаал18

Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал:19

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
УИХ	Улсын их хурал
ЗГ	Засгийн газар
ҮАГ	Үндэсний Аудитын газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс
ХАМО	Хувиараа ашигт малтмал олборлогч
БУУАМО	Бичил уул уурхайгаар ашигт малтмал олборлогч
БУО	Бичил уурхайн олборлолт
ТББ	Төрийн бус байгууллага
ХХК	Хариуцлагатай хувьцаат компани
ХБО	Хууль бус олборлолт
Хүснэгт -1	Бичил уурхайгаар ашигт малтмал олборлож буй аж ахуйн нэгжийн судалгаа
Хүснэгт -2	Хувиараа ашигт малтмал олборлогчдын үйл ажиллагаанаас өртөж эвдэрсэн газрын мэдээлэл
Хүснэгт-3	Уул уурхайн ашиглалт, хайгуулын үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газар
Хүснэгт-4	Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлосны улмаас эвдэрсэн газар
Хүснэгт-5	Төрийн бус байгууллагын санаачилгаар нөхөн сэргээлт хийсэн талбай
Зураг-1	Дөргөн сумын Хөх эргийн аараг. Олборлолтоос эвдэрсэн газрын нөхөн сэргээлт хийсэн талбай
Зураг-2	Булган сумын Баян судал баг. Цоохор нуурын хууль бус олборлолт хийсэн нөхөн сэргээгдээгүй талбай
Зураг-3	Алтай сумын Оцог хад. Хууль бус олборлолтоор эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийгдээгүй талбай
Зураг-4	Алтай сумын Хөх булаг. Хууль бус олборлолтоос эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийгдээгүй
Зураг-5	Цэцэг сумын Баян овоо баг. Улсын тусгай хамгаалалттай газар нутагт хууль бус олборлолт хийж нөхөн сэргээлт хийгдээгүй газар

1.1.Аудит хийх бүрэн эрх, үндэслэл: Аудитыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2019 оны аудитын сэдэв батлах тухай 05 дугаар тогтоол, Монгол улсын Ерөнхий аудиторын 2019 оны А/100 дугаар тушаалаар баталсан Үндэсний Аудитын газрын 2020 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

1.2 Аудитын зорилт: Бичил уул уурхайгаар ашигт малтмал олборлох журмын хэрэгжилтэд нийцлийн аудит хийж дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэнэ. Аудитын зорилтыг ханган биелүүлэхийн тулд дараах чиглэлээр аудит хийнэ.

- Орон нутгийн захиргаа, мэргэжлийн байгууллагууд бичил уурхайн талаар авч хэрэгжүүлсэн бодлого үр дүнтэй байгаа эсэх
- Бичил уул уурхайн орчны байгаль хамгаалал, нөхөн сэргээлт хууль журамд нийцсэн эсэх
- Уул уурхайн хууль бус олборлолтод тавих хөндлөнгийн болон дотоод хяналт үр нөлөөтэй хэрэгжсэн эсэх

1.3 Аудитын хамрах хүрээ: Аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газар, Мэргэжлийн хяналтын газар, Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, сумдын ЗДТГазар, Бичил уул уурхай эрхэлж буй аж ахуйн нэгж хувь иргэдийн 2016-2019 оны үйл ажиллагаа хамрагдсан болно.

1.4 Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт: Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, АДБОУС 400, АДБОУС 3000, АДБОУС 4000 дугаар стандартууд, Төрийн хяналт шалгалтын стандарт, нийцлийн аудитын түр журмыг баримтлан Санхүү, төрийн сангийн хэлтэс, Хөрөнгө оруулалтын хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, сумдын ЗДТГ болон холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, судалгаа авч шинжилгээ хийх, санхүүгийн тайлан, хөрөнгийн данс, анхан шатны баримт, ажлын төлөвлөгөө, тайлантай тулган баталгаажуулах арга зүйг ашиглан аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох бусад мэдээллийг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитад Ашигт малтмалын тухай хууль, Байгаль орчны тухай хууль, Төрийн аудитын тухай хууль, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай”, Газрын хэвлийн тухай” хууль, Байгаль хамгаалах нөхөн сэргээх тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Бичил уул уурхайгаар ашигт малтмал олборлох журам, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль, ИТХ-аас гарсан тогтоол, шийдвэр, Зохицуулах зөвлөл болон Удирдах зөвлөлөөс гарсан тушаал болон бусад холбогдох дүрэм, журам, засгийн газрын тогтоолуудыг ашигласан.

Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн: Аудитыг газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар удирдан, аудитын менежер А.Цэцэгсүрэн аудитын арга зүйгээр хангаж, үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлж, аудитор Д.Эрдэнэцэцэг гүйцэтгэв.

Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл: Аудитын тайлангийн I бүлэгт бичил уул уурхайн талаар авч хэрэгжүүлсэн бодлого, II бүлэгт бичил уул уурхайн дараах нөхөн сэргээлт, түүнд тавих хяналт, III бүлэгт Уул уурхайн олборлолтод тавих хяналтын талаар тайлагнаж ерөнхий зүйл, аудитын дүн, аудитын дүгнэлт, зөвлөмж, холбогдох газрын санал гэсэн агуулгаар бичлээ.

Аудитад учирсан хүндрэл бэрхшээл: Аудит хийх явцад ХОХБТХ-ийн мэргэжилтэн бичил уул уурхайн талаар хяналт хийсэн нэгдсэн тайлан, мэдээ судалгаа бүрэн ирүүлээгүй, Булган сумын байгаль орчны байцаагчийн ажлын тайлан баримт хангалтгүй, сумдын хууль бус олборлолт хийсэн газрын эзэн холбогдогч нь тодорхой бус, бичил уул уурхай эрхэлж буй аж ахуйн нэгж байгууллагын эзэд олдохгүй байх зэргээс шалтгаалан аудитыг гүйцэтгэхэд хүндрэл бэрхшээлтэй байлаа.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Ховд аймагт Ашигт малтмалын хэрэг эрхлэх газрын судалгаагаар тусгай зөвшөөрөлтэй 8.0га талбайтай ашиглалтын 22, 545.4 мян га талбайтай хайгуулын 78 лизенц байгаа бөгөөд нийт нутгийн 7.3 хувийг хамарсан 553.3 мянган га талбай бүхий 100 тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байгууллага үйл ажиллагаа явуулж байна.

Аймгийн хэмжээнд бичил уул уурхайгаар ашигт малтмал олборлох журмын дагуу¹ авч хэрэгжүүлсэн ажлын хүрээнд хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн үйл ажиллагаа болон уул уурхайн ашиглалтын улмаас 7 сумын 37 газрын 160 га талбай эвдрэлд орсон талаарх урьдчилсан судалгаа байна. Үүнээс 2016-2017 оны хооронд орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөрийн байгууллагуудын санхүүжилтээр нөхөрлөл, аж ахуйн нэгж байгууллагаар 65 орчим га талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг хийлгэсэн мэдээ байгаа боловч эвдэрсэн газар дээр нь ажиллаж, хэмжилт хийх, мэдээлэл цуглуулах, бодит тоон мэдээтэй болох, судалгааг нарийвчлан гаргаагүй байна.

Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшиж үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагууд нь “Байгаль орчныг хамгаалах тухай”, “Ашигт малтмалын тухай”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай”, “Газрын хэвлийн тухай” хуулийн дагуу уурхайн олборлолт явагдаж дууссан талбайд эвдэрсэн газрын техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг хийж гүйцэтгэн хүлээлгэж өгөх үүрэг хүлээдэг бөгөөд одоогийн байдлаар олборлолтын ажил дуусаж хүлээлгэн өгсөн талбай байхгүй байна.

Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хүрээнд 2018 онд байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 5.0 сая төгрөгийг төсөвлөж дээрх удирдамжийн дагуу аймгийн Засаг даргын 2018 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн А/323 дугаар захирамж гарч эвдэрсэн газрын тооллого хийх ажлын хэсэг байгуулагдан ажилласан байна.

¹ Энэхүү журмын зорилго нь үйлдвэрлэлийн аргаар ашиглахад эдийн засгийн үр ашиггүй орд, ашиглалтын болон технологийн хаягдлаар бий болсон талбайд ашигт малтмалыг зүй зохистой олборлох журмыг тогтоож, байгаль орчныг хамгаалах, орон нутагт ажлын байрыг нэмэгдүүлж ядуурлыг бууруулахад оршино.

Тооллого судалгаанаас үзэхэд аймгийн хэмжээнд 13 сумын 22 багийн 52 нэгж талбайг хамарсан 276.64 га талбайд газар дээр нь ажиллаж мэдээлэл цуглуулсанаас нөхөн сэргээлт хийх шаардлагагүй буюу байгалийн жамаар нөхөн сэргээгдэж буй 17 газрын 76.66 га талбай байна. Нөхөн сэргээгдэх боломжгүй 9 сумын 36 газрын 199.98 га талбай эвдэрсэн байгаагаас 76.62 га талбайд “МоЭнКо” ХХК, “Талст молор” ХХК, “Булган стар” ХХК, “Брит осиенс куание” ХХК-ниуд хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагаа зөвшөөрөлгүй явуулсан бөгөөд цаашид энэхүү эвдэрсэн газрын хэмжээ нь нэмэгдэх төлөвтэй байна.

Бүлэг1: Бичил уул уурхайн талаар засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдсан ажил хэрэгжсэн боловч бичил уурхай эрхлэгчид байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд хамрагдаж менежмент төлөвлөгөө батлуулаагүй байна.

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт бичил уурхайн чиглэлээр хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй хэрэгжсэн байна.

1.1. Аймгийн засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 3.4.1-д “Хууль бус аргаар ашигт малтмал олборлосны нөлөөгөөр эвдрэлд орж эзэнгүй орхигдсон газруудад нөхөн сэргээлт хийх”, 3.4.2-д тусгагдсан “холбогдох журмын дагуу ХАМО буй иргэдийг албажуулан зохион байгуулалтад оруулах замаар байгаль орчныг хамгаалах хариуцлагыг нэмэгдүүлэх” гэсэн 2 ажил тусгагдсан байна. Мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дараах ажлуудыг хийсэн байна. Үүнд:

- ✓ Бичил уул уурхайгаар ашигт малтмал олборлох журмын 8-р зүйлийн 8.1.2², 8.1.4³-д заасны дагуу 2018 онд Алтай Булган Үенч Мөст Цэцэг Дөргөн сумдын Засаг дарга, байгаль орчны байцаагч, байгаль хамгаалагч, газрын даамал, ХАМО иргэд нөхөрлөлийн төлөөлөлд бичил уурхайн чиглэлээр төрөөс баримталж буй бодлого, хууль эрх зүй, бичил уурхайгаас бусад чиглэлээр хөдөлмөр эрхлэх, мэргэжил эзэмших боломжийн талаар зөвлөгөөн хийсэн
- ✓ Ажил олгогч эздийн холбоо ТББ-тай гэрээ байгуулан ХАМО иргэдийн судалгаа хийлгэснээр нийт ХАМО иргэд 582 иргэн байна гэсэн судалгаа гарсан
- ✓ 2019 онд Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмын хэрэгжилтийг хангуулах, хууль бус ашигт малтмал олборлож байж болзошгүй газруудад газар дээр нь ажиллаж, хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох, хууль журмын хүрээнд үйл ажиллагаа явуулахад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилгоор Алтай, Мөст, Цэцэг сумдад хяналт хийсэн

² тухайн аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилттой уялдуулан бичил уурхайн үйл ажиллагаа явуулах талбайг сум, дүүргээр бүсчилсэн байдлаар хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулах;

³ энэхүү журмын 8.1.2-т заасан төлөвлөгөөний дагуу бичил уурхайн зориулалтаар тусгай хэрэгцээнд авсан газарт бичил уурхай эрхлэх үйл ажиллагааг нэгдсэн зохион байгуулалтад оруулах талаар сум, дүүргийн Засаг дарга нарыг нэгдсэн удирдлагаар хангах;

- ✓ Хууль бус аргаар ашигт малтмал олборлосон нөлөөгөөр эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийг Дөргөн сумын Аргалант багийн нутаг Хөх эргийн аараг хэмээх газарт иргэд алт олборлох үйл ажиллагаа явуулж 3.5 га талбай эвдрэлд оруулсан бөгөөд “Блю гоулд” ХХК-нь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 60 дугаар тогтоолоор батлагдсан “Эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийх, хяналт тавих” журмын хүрээнд нөхөн сэргээлт хийх гэрээг 2017 онд байгуулан ажиллаж 2018 оны сумын Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг хүлээн авсан байна.
- ✓ Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан ажлын хүрээнд 2018 оны төсөвт байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 5.0 сая төгрөгийг шийдүүлэн дээрх удирдамжийн дагуу аймгийн Засаг даргын 2018 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн А/323 дугаар захирамж гарч эвдэрсэн газрын тооллого хийсэн



Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд хамрагдаж байгаль орчныг хамгаалах менежмент төлөвлөгөө боловсруулан батлуулж хэрэгжилтийг хангаж ажиллаагүй байна.

1.2 Нөхөрлөлийн бүх гишүүдийн хурлаар хэлэлцсэн байгалийн нөөцийн хамтын менежмент явуулах нөхөрлөлийн ашиглах байгалийн нөөцийн тархцын хил хязгаар, тоо хэмжээ, даац, чанар зэрэг үзүүлэлт, менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд нөхөрлөлийн гишүүд тус бүрийн гүйцэтгэх үүрэг болон оролцогч талтай хамтрах ажиллах менежмент төлөвлөгөөг аудитын явцад ирүүлээгүй. Бичил уурхай эрхлэгч аж ахуйн нэгжүүдэд байгаль хамгаалах тухай хуулийн 50-р зүйлийн 50.4⁴, 50.10⁵, 50.11⁶ дахь заалт хангалтгүй хэрэгжиж байгаа дараах зөрчлүүд байна. Тухайлбал:

- ✓ Бичил уул уурхайгаар ашигт малтмал олборлох баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын санал, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэргүй
- ✓ Нөхөрлөлийн байгалийн нөөцийн менежмент явуулахыг хүссэн өргөдөл хавсаргаагүй
- ✓ Нөхөрлөлийн бүх гишүүдийн хурлаар хэлэлцэж баталсан байгалийн нөөцийн хамтын менежмент явуулах менежментийн төлөвлөгөөгүй
- ✓ Нөхөрлөл байгуулсан гишүүдийн хамтран ажиллах тухай гэрээ болон иргэний үнэмлэхний хуулбар Мөст сумын Бодонч их бүрд нөхөрлөлөөс бусад нь хавсаргаагүй
- ✓ Нөхөрлөл байгалийн нөөцийн менежментийн талаарх тайланд байгалийн баялгийг хамгаалах, ашиглах, нөхөн сэргээхэд зарцуулсан хөрөнгийн зарцуулалт, түүний үр дүн, нөөц баялгийн төлөв байдал, түүний өөрчлөлт зэргийг тусгаж сумын удирдлага баг хорооны хуралд тайлагнаагүй

⁴ Сум дүүргийн Засаг дарга дараах баримт бичгийг үндэслэн байгаль хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулах иргэдийн нөхөрлөлтэй гэрээ байгуулан хамтран ажиллаж, тэдний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулна:

⁵ Нөхөрлөл нь өөрийн дотоод дүрэмтэй байх бөгөөд дүрмэндээ бүх гишүүдийн хурал, удирдах зөвлөл, хяналтын зөвлөл, ахлагч, гишүүний эрх, үүрэг, хариуцлага, дундын өмч хөрөнгийн харилцааны асуудлыг хуульд заасны дагуу тусгасан байна.

⁶ Нөхөрлөл байгалийн нөөцийн менежментийн талаарх тайланг жил бүр тухайн сум, дүүрэг, баг, хорооны Хуралд тайлагнах бөгөөд түүнд байгалийн баялгийг хамгаалах, ашиглах, нөхөн сэргээхэд зарцуулсан хөрөнгийн зарцуулалт, түүний үр дүн, нөөц баялгийн төлөв байдал, түүний өөрчлөлт зэргийг тусгасан байна.

1.3 Алтай сумын Майхан-1, 2, Тэсэгтэй-1, 2, 3 газрууд Мөст сумын нарийн дав Бодонч их бүрд ХХК-нь бичил уул уурхайгаар ашигт малтмал олборлох явцад байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл, үр дагаврыг урьдчилан тодорхойлж, түүнийг бууруулах, арилгах арга хэмжээг тусгасан байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийлгээгүй байгаа нь байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэх тухай хуулийн 3-р зүйлийн 1.6⁷-р заалт, 7-р зүйлийн 7.3⁸-р заалтууд хэрэгжихгүй байна.

Бичил уул уурхайн ашигт малтмал олборлох журмын дагуу газар нутгийг орон нутгийн тусгай хэрэгцээнд авах ИТХ-ын тогтоол шийдвэр хуулийн хүрээнд хэрэгжсэн байна.

1.4 Хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагаа явуулж буй иргэдийн үйл ажиллагааг дэмжих, албажуулах, зохион байгуулалтад оруулах, орон нутгийн хөгжлийг дэмжих, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор 8 газрыг тусгай хэрэгцээнд авсан байна. Газар нутгийг орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан газрыг хүснэгтээр харуулбал:

/Хүснэгт-1/

Бичил уурхайгаар ашигт малтмал олборлож буй аж ахуйн нэгжийн судалгаа													
д/д	Сум	Талбайн нэр / тусгай зөвшөөрлийн дугаар	Солбицол	Олборлолт явуулж байгаа талбайн хэмжээ (га)	Ашигт малтмалын төрөл	Ашиглалт		Нөхөрлөл, хоршоо,				Олборлолт явуулж эхэлснээс хойш эвдрэлд орсон талбай (га)	Нөхөн сэргээлт хийсэн талбай (га)
						Ил	Далд	Бичил уурхай эрхлэгч этгээдийн нэр	ИТХ-ын тогтоол шийдвэр	Гэрээ байгуулж, олборлолт эхэлсэн огноо	Гишүүдийн тоо		
1	Мөст	Нарийн давийн ам	92/25-46/27	25.79	Вольфрам		+	Бодонч Их Бүрд нөхөрлөл	2018.06.27/7/4627/ИТХ/08	2015.09.02	11	1.5	байхгүй
2	Мөст	Нарийн дав		5.25	Алт		+	Бодонч Их Бүрд нөхөрлөл	Зөвшөөрөлгүй. Хуулийн байгууллагаар шалгагдаж байгаа				
3	Алтай	Майхан-1	92/13-45/44	0.23	Алт		+	Алтайн говь Цонж	2019.07.25/7/5337ИТХ/9/10	2019.09.09	9	1	байхгүй
4	Алтай	Майхан-2	92/13-45/44	0.81	Алт		+	Бодонч нутгийн хишиг	2019.07.25/7/5337ИТХ/9/11	2019.09.02	9	4х4 хэмжээтэй 6-7м гүнтэй 1	байхгүй
5	Алтай	Улаан богоч	92/21-46/18	5	Алт		+	Бодонч нутгийн хишиг	2019.07.30/7/5436ИТХ/9/09	Газрын координатаа буруу сонгосон шалтгаанаар уг газарт гэрээ хийгдээгүй			
6	Алтай	Тэсэгтэй-1	92/23-45/42	3	Алт		+	Алтайн говь Цонж	ИТХ-ын 9/07	АМГТГ-аас дүгнэлт ирээгүй, кадастрийн хэлтсийн мэдээллийн санд бүртгэлтэй.			
7	Алтай	Тэсэгтэй-2	92/23-45/42	3	Алт		+	Алтайн говь Цонж	ИТХ-ын 9/08	АМГТГ-аас дүгнэлт ирээгүй, кадастрийн хэлтсийн мэдээллийн санд бүртгэлтэй.			
8	Алтай	Тэсэгтэй-3	92/23-45/41	1	Алт		+	Алтайн говь Цонж	ИТХ-ын 9/09	АМГТГ-аас дүгнэлт ирээгүй, кадастрийн хэлтсийн мэдээллийн санд бүртгэлтэй.			
9	Ховд	Согоот	92/35-48/12	5	Алт		+	-	ИТХ-ын 9/06	АМГТГ-аас дүгнэлт ирээгүй, кадастрийн хэлтсийн мэдээллийн санд бүртгэлтэй.			

Хүснэгтээс харахад Ашигт малтмал газрын тосны газрын дүгнэлт ирээгүй байхад 4 газрыг кадастрын мэдээллийн санд бүртгэлтэй байгаа учир бичил уул уурхайгаар

⁷ байгаль орчны нөлөөллийн үнэлгээ гэж иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас тодорхой төслийг хэрэгжүүлэх явцад байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл, үр дагаврыг урьдчилан тодорхойлж, түүнийг бууруулах, арилгах арга хэмжээ тогтоохыг;

⁸ Төсөл хэрэгжүүлэгч нь холбогдох эрх бүхий байгууллагаар баталгаажсан техник-эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчны өнөөгийн төлөв байдлын тодорхойлолт, тухайн сум, дүүргийн Засаг даргын санал болон холбогдох бусад баримт бичгийг бүрдүүлэн энэ хуулийн хавсралтад заасан ангиллын дагуу байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл байгаль орчны албанд байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийлгэнэ.

ашигт малтмал олборлох журмын 7-р зүйлийн 7.1.2⁹-д заасны дагуу ИТХ-ын тогтоолоор тусгай хэрэгцээнд авсан тогтоол гарсан байна. Алтай сумын Улаан богоч гэх газар газрын координатаа буруу сонгосон учир гэрээ хийгдээгүй байна.

Бүлэг2: Эвдэрсэн газрыг нөхөн сэргээхэд шаардлагатай зардлыг холбогдох хуулийн дагуу төлөвлөж, төсөвт тусгаагүйгээс эвдэрсэн газруудыг нөхөн сэргээх, орчныг хамгаалах ажлууд хийгдэхгүй байна.

Бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалыг байгаль орчны асуудал эрхэлсэн байгууллагатай хамтран баталж, хэрэгжилтийг хангаж ажиллаагүй байна.

2.1 Бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалыг баталж аж ахуйн нэгж байгууллагуудтай гэрээ байгуулсан, гүйцэтгэлийг хянасан талаарх тайланг аймгийн Засаг даргад хүргүүлж зөвлөмж мэдэгдэл гаргуулж арга хэмжээ авсан тайлан мэдээ байхгүй байна. Бичил уул уурхайгаар ашигт малтмал олборлох журмын 3-р зүйлийн 3.2.2¹⁰, 6-р зүйлийн 6.1.7¹¹-р заалт, 8-р зүйлийн 8.1.11¹²-р заалт бүхий журмын хэрэгжилт хангагдаагүй дараах зөрчлүүд байна. Тухайлбал:

- ✓ Бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаагүй
- ✓ Бичил уурхай эрхэлж байгаа нөхөрлөлүүд нийгмийг хөгжүүлэх чиглэлээр хийсэн дорвитой ажил байхгүй
- ✓ Мөст сумын Нарийн дав бичил уурхайн Бодонч их бүрд ХХК-ны нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, тайлан ирүүлсэн боловч сумын удирдлагын зүгээс хүлээн авсан, хийж хэрэгжүүлсэн ажлыг нь дүгнэж зөвлөмж хүргүүлээгүй,

Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөг бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалын дагуу хийж нөхөн сэргээлтийн зардалд шаардагдах хөрөнгө төвлөрүүлж нөхөн сэргээлт хийсэн баримт байхгүй байна.

2.2 Бичил уул уурхай эрхлэгч аж ахуйн нэгжүүд нөхөн сэргээлтийн төлөвлөгөөг бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалын хавсралтаар баталсан загварын дагуу батлуулж, нөхөн сэргээлтийн зардалд шаардагдах хөрөнгө төвлөрүүлж, бичил уурхайгаар ашигт малтмал олборлох гэрээнд хавсаргасан баримт байхгүй байна. Тухайлбал:

- ✓ Мөст сумын Бодонч их бүрд нөхөрлөл нөхөн сэргээлтийн зардалд шаардагдах хөрөнгө төвлөрүүлсэн баримтгүй, нөхөн сэргээлт хийсэн хүлээн авсан актыг бичил уурхайгаар ашигт малтмал олборлох гэрээнд хавсаргаагүй
- ✓ Сумын удирдлага аж ахуйн нэгжүүдээр нөхөн сэргээлт хийлгэж, нөхөн сэргээлт хийсэн талбайг комисс томилон хүлээж авах, энэ талаарх тайланг аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлээгүй,

⁹ аймаг, нийслэлийн Засаг даргын бичил уурхайн зориулалтаар газрыг тусгай хэрэгцээнд авах талаар гаргасан саналыг хэлэлцэн шийдвэрлэж, шийдвэрээ ажлын 5 өдөрт багтаан хүргүүлэх.

¹⁰ нөхөн сэргээлтийн төлөвлөгөөг бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалын хавсралтаар баталсан загварын дагуу батлуулж, нөхөн сэргээлтийн зардалд шаардагдах хөрөнгө төвлөрүүлж, бичил уурхайгаар ашигт малтмал олборлох гэрээнд хавсаргасан байх;

¹¹ нөхөн сэргээлт хийлгэж, нөхөн сэргээлт хийсэн талбайг комисс томилон хүлээж авах, энэ талаарх тайланг аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлэх;

¹² бичил уурхайн нөхөн сэргээлтийн ажилд хяналт тавих ажлыг зохион байгуулах;

- ✓ Алтай сумын Майхан-1, Майхан-2 нөхөн сэргээлтийн төлөвлөгөөг бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалын хавсралтаар баталсан загварын дагуу батлуулаагүй, нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгө хэрхэн төвлөрүүлсэн баримт байхгүй

Нөхөн сэргээлт хийгээгүй болон ашигт малтмал олборлох гэрээний үүргээ биелүүлээгүй бичил уурхай эрхлэгч этгээдтэй хариуцлага тооцоогүй байна.

2.3 Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хууль бус үйл ажиллагааны улмаас байгаль орчны алдагдсан тэнцлийг болон байгалийн баялгийг нөхөн сэргээх, хүн амыг нүүлгэх, мал, амьтныг тухайн нутаг дэвсгэрээс шилжүүлэхэд гарсан зардлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэхээр экологи эдийн засгийн үнэлгээ хийлгэж орон нутгийн удирдлагын зүгээс хууль хяналтын байгууллагад хандсан асуудал байхгүй байна. Эвдэрсэн газрын судалгааг хүснэгтээр харуулбал: /Хүснэгт-2/

Хувиараа ашигт малтмал олборлогчдын үйл ажиллагаанаас өртөж эвдэрсэн газрын мэдээлэл					
№	Сумын нэр	Багийн нэр	Газрын нэр	Эвдэрсэн талбай /га/	малт малын төрөл
1	Алтай	Бодонч	Сэнжит хад	2.1	алт
			Яргайтын тоом	1	алт
			Түймэртийн тоом	1.3	алт
			Хүрэн бухт	1	алт
			Улаан дав	0.1	алт
			Хөх бухт	0.6	алт
			Тамт	13.6	алт
			Оцог хад	0.09	гиант болд
			Улаан богоч	0.3	гиант болд
			Хар давын ам	2	алт
			Ендэрт ус	0.7	алт
			Хужир түнгэ	0.01	алт
			Хойд өвөр булгийн ам	1	алт
		Нарийн давын ам	0.2	алт	
		Алтангадас	Дэрстэй	3.9	алт
			Хөх булаг	0.9	алт
			Халиуны амны зоо	0.4	алт
Тэсэгтэй	2		алт		
Майхан хар	2.6		алт		
		Нарийн хар	0.3	алт	
2	Булган	Баянсудал	Црохор нуур	2.6	алт
		Байтаг	Таталын гурван толгой	0.09	алт
		Алагтолгой	Тэмээний хонд	0.1	алт
		Байтаг	Цөмөрдөг толгой	3	алт
		Црохор нуур	Баян судал	2.6	Алт
		Байтаг	Их улаан уул /Засаг цагаан/	2.1	алт
3	Үенч	Нарийн гол	Загийн ам	1.5	алт
			Дарьтын богоч	0.05	алт
			Нарийн сайрын ам	0.05	алт
			Дарьтын шил	0.07	алт
4	Мөст	Хужирт	Нарийн дав	1.06	гиант болд
5	Цэцэг	Баян-Овоо	Хүрэн толгой	0.4	алт
			Цагаан эрэг	41	
6	Ховд	Цагаан бургас	Хогийн худаг	0.6	алт
			Баруун салаа	Ар согоот	0.4
Нийт				89.52	

Хүснэгтээс харахад 6 сумын 10 багийн 34 газрын 89.52 га талбай хувиараа ашигт малтмал олборлогчдын хууль бус үйл ажиллагаагаар эвдрэлд орсон байна. Байгаль хамгаалах тухай хуулийн 16-р зүйлийн 16.1.1¹³-д заасны дагуу ашигт малтмал

¹³ нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ, төсөв баталж, биелэлтэд хяналт тавих;

олборлолтын улмаас эвдэрсэн газрыг нөхөн сэргээх төсөв баталж хийж хэрэгжүүлсэн ажил байхгүй хууль бус үйл ажиллагаа бүрэн зогсоогүй байна.

Бүлэг3: Мэргэжлийн байгууллагуудын хяналт, шалгалтын үйл ажиллагаа үр нөлөөтэй хэрэгжихгүй байгаагаас хууль бус олборлолтоос үүссэн эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, экологи эдийн засгийн үнэлгээ хийгдээгүй байна.

Байгаль хамгаалах, нөхөн сэргээх, мэдээллийн сан бүрдүүлэх ажил хууль тогтоомжийн дагуу хэрэгжээгүй байна.

3.1 Бичил уурхай эрхэлж байгаа зөвшөөрөлтэй болон хууль бус олборлолтоор байгаль орчинд хохирол учруулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын тухай мэдээлэл, байгаль орчинд учруулсан хохирлын экологи-эдийн засгийн үнэлгээ, ногдуулсан хохирлын нөхөн төлбөрийн хэмжээ, байгаль орчинд учруулсан хохирлын нөхөн төлбөр төлсөн, хохирлыг арилгасан тухай мэдээллийг мэдээллийн санд бүрдүүлсэн баримт байхгүй байгаа нь байгаль хамгаалах тухай хуулийн 36-р зүйл 1.2.3¹⁴-р заалт хэрэгжээгүй байна. Тухайлбал:

- ✓ Хууль бусаар ашигт малтмал олборлож байгаль орчинд хохирол учруулсан иргэн аж ахуйн нэгж байгууллагын эзэн холбогдогч тодорхой бус хариуцах эздийн мэдээлэл байхгүй
- ✓ Байгаль орчинд учруулсан хохирлын экологи эдийн засгийн үнэлгээ хийж нөхөн төлбөрийн хохирлын хэмжээг тооцоогүй
- ✓ Бичил уурхайгаар ашигт малтмал олборлосон аж ахуйн нэгж, хууль бус олборлолт хийж ашиг олсон хувь иргэдийн ашигт малтмал олборлосон, ус ашигласан, хогны төлбөрт төлсөн төлбөрийн мэдээлэл байхгүй
- ✓ Бичил уурхайн зориулалтаар бичил уурхай эрхлэгч этгээдийн талаарх нэгдсэн судалгаа бүхий мэдээллийн сан бүрдүүлж холбогдох байгууллагад шинэчлэн хүргүүлээгүй
- ✓ Бичил уурхайн ажилтнуудыг нийгмийн халамжийн үйлчилгээ болон нийгмийн даатгалд хамруулсан мэдээлэл байхгүй

Хууль бус болон зөвшөөрөлтэй олборлолт хийсэн эвдэрсэн газрын экологи, эдийн засгийн үнэлгээ хийгээгүй, хохирлыг тооцоогүй байна.

3.2 Байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх тодорхой асуудлаар аймгийн хэмжээнд авч хэрэгжүүлсэн ажил нь Алтай сумын Тамт хэмээх газарт 3 га талбайд “Түлхэц хад” нөхөрлөл техникийн нөхөн сэргээлт хийж, сумын Засаг даргын А/119 дугаар захирамжаар ажлын хэсэг байгуулагдан хүлээж авсан байна.

3.3. Уул уурхайн ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орж байгальд учруулсан хохирлыг тооцож гаргаагүй олборлолт хийгдсэн газрын нөхөн сэргээлт хийсэн хүлээн авсан акт баримт байхгүй барьцаа хөрөнгө хэрхэн зарцуулагдаж байгаа баримт байхгүй байна. Уул уурхайн зориулалтаар ашигт малтмал олборлож хайгуул хийсэн эвдэрсэн газрын судалгааг хүснэгтээр харуулбал.

/Хүснэгт 3/

¹⁴ байгаль орчинд хохирол учруулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын тухай мэдээлэл;
- байгаль орчинд учруулсан хохирлын экологи-эдийн засгийн үнэлгээ, ногдуулсан хохирлын нөхөн төлбөрийн хэмжээ;
- байгаль орчинд учруулсан хохирлын нөхөн төлбөр төлсөн, хохирлыг арилгасан тухай тайлан.
Аудитын код: ХОА-2020/06/-НА

Уул уурхайн ашиглалт, хайгуулын үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газар						
№	Сумын нэр	Багийн нэр	Газрын нэр	Аж ахуйн нэгж байгууллагын нэр	Эвдэрсэн талбайн хэмжээ /га/	Ашигт малтмалын төрөл
1	Алтай	Бодонч	Оцог хад	“Талст молор” ХХК	2	Гянтболд
			Хөх булаг /Чонот/	“Брит осиенс куание” ХХК	0.07	Гянтболд
2	Булган	Байтаг	Геологийн цагаан толгой	Хайгуулын анги 1950-1960	1.1	Болор
3	Мөст	Хужирт	Нарийн дав	“Булган стар” ХХК	1.6	Гянтболд
		Цэцэг гол	Цагаан хөтөл /Төгөл/	“Идеал систем” ХХК	3.5	Алт
4	Цэцэг		Цахир булаг	“ЛУВР” ХХК	22	Алт
		Хөшөөт	Хөшөөт	“МоЭнКо” ХХК	72,95	Нүүрс
Нийт					103.22	

Судалгаанаас үзэхэд 4 сумын 7 газрын 103.22¹⁵ га талбай эвдрэлд орж нөхөн сэргээлт хийгдээгүй байгаль орчинд учруулсан хохирлыг тооцоогүй байна.

3.4 Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлосны улмаас эвдрэлд орсон газрын нөхөн сэргээлт хийгээгүй байна. Түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолт, хайгуул хийсний улмаас эвдрэлд орсон газрыг хүснэгтээр харуулбал: /Хүснэгт-4/

Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлосны улмаас эвдэрсэн газар						
№	Сумын нэр	Багийн нэр	Газрын нэр	Аж ахуйн нэгж байгууллагын нэр	Эвдэрсэн талбайн хэмжээ /га/	Ашигт малтмалын төрөл
1	Булган	Бүрэнхайрхан	Хайрганы карьер	Автозамын компани	3.1	Хайрга
			Цагаан шал	“Од Цэ” ХХК 2005	42.2	Шар шавар
				“Жаргалант рашаант” ХХК 2010	30	Шар шавар
				Цагаанбулан	Цавын дугуй	Иргэд
2	Мянгад	Баянхошуу	Ховд голын эрэг дагуу	Иргэд	0.1	Хар шавар
3	Эрдэнэбүрэн	Шураг	Гурван-толгой	“Буянт стандарт” ХХК 2013	0.2	Чулуу
4	Манхан	Төгрөг гол	Зах булгын ар	2011 “ГЕЗУВА” ХХК	0.6	Хайрга
5	Буянт	Норжин-хайрхан	Дөрвийн газрын шавр	Иргэд	3	Шар шавар
		Цагаан эрэг		“Ховдын тулга” ХХК	2.2	Хайрга
6	Жаргалант	Рашаант	Бугат үзүүр	“Жаргалант луу” ХХК	1.2	Хайрга
		Бичигт		Иргэд	2.7	Элс
Нийт					86.1	

Хүснэгтээс харахад түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолтын улмаас 6 сумын 9 багийн 10 нэгж талбайн 86.1 га газар эвдэрсэн байна. Үүнээс аж ахуйн нэгж байгууллагын эвдрэлд оруулсан 79.5 га талбай нөхөн сэргээлт хийгдээгүй байгаль учруулсан хохирлыг тооцож экологи эдийн засгийн үнэлгээ хийгээгүй байна.

3.5 Хууль бус аргаар ашигт малтмал олборлож байгаль орчинд хохирол учруулсан иргэн аж ахуйн нэгжүүдэд газрын хэвлийд учирсан хохирлыг байгаль орчныг

¹⁵ БОАЖСайдын 2017 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А/71 тоот тушаалаар баталсан тооллого хийх хүснэгтийн дагуу эвдэрсэн газруудад газар дээр нь очиж өнөөгийн ерөнхий төлөв, төрх байдлыг тодорхойлох, хэмжилт хийж талбайн хэмжээ, солбилцолыг тогтоох, эвдэрсэн газрын тооллогын судалгаа

хамгаалах тухай хуулийн 20-р зүйлийн 20.3¹⁶-р заалт, 21-р зүйлийн 21.3¹⁷ дахь заалт, 49-р зүйлийн 49.4¹⁸ дэх заалтын хэрэгжилтийг хангаж байгаль орчинд учирсан хохирлыг тооцох аргачлалаар тооцсон хохирлын хэмжээг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр, хөрсөнд учирсан хохирол, байгаль орчныг бохирдуулснаас үүсэх хохирлыг байгаль орчинд учирсан хохирлыг тооцох аргачлалаар тооцсон хохирлын хэмжээг гурав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр тооцож дүгнэлт гаргаж нөхөн төлүүлсэн асуудал байхгүй байна. Тухайлбал:

- ✓ Булган сумын Баян судал багийн нутаг Цоохор нуурын орчимд 2007 онд ХАМО иргэд 2.6 га талбайг хамарсан 3 хэсэг газар гар аргаар болон техникээр эвдрэлд оруулж нөхөн сэргээлт хийж байгальд учруулсан хохирлыг тооцож экологи эдийн засгийн үнэлгээг хийгээгүй. Тус газар нь “Жи Эс Би Майнинг” ХХК-ний Цохоор нэртэй хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд хамаарагдаж байгаа бөгөөд усны хамгаалалтын бүстэй давхацсан байна.



- ✓ Алтай сумын Оцог хад нэх газарт “Талст молор” ХХК 2016 оноос эхлэн хайгуулын үйл ажиллагаа явуулж, уулын далд нэвтрэлтийн ажлыг зөвшөөрөлгүй хийж 430 м урт суваг малтаж 2 га талбай эвдэрч нөхөн сэргээлт хийгээгүй. Тухайн байгууллагын хайгуулын ажил хийж буй талбайд хувиараа ашигт малтмал олборлогч иргэд 10 м гүнтэй 1,5 м хүртэл өндөр овоолго шороотой 1 га талбайд олборлолт хийж газар эвдэрсэн байгааг нөхөн сэргээлт хийлгэж хохирлыг тооцоогүй



- ✓ Алтай сумын Хөх булаг газарт “Брит осеонс куание” ХХК 157.08 га талбайд MV-017624 тоот ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшиж үйл ажиллагаа явуулахаар төлөвлөсөн ба 2014 онд хувиараа ашигт малтмал олборлогч иргэд 80 м урт, 2.5 м өргөн, 2м өндөр тунел үүсгэн олборлолт явуулсан байгаагаас 0.07 га талбай эвдэрч хүн малд аюултай орчин үүссэн байгаад хяналт хийж нөхөн сэргээлт хийлгэн байгаль орчинд учруулсан хохирлыг тооцоогүй байна.



¹⁶ Байгаль орчны чадавхийн тогтоосон хэм хэмжээг хэтрүүлэн байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага байгаль орчинд учруулсан хохирлыг өөрөө арилгах буюу мэргэжлийн байгууллагаар арилгуулж гарсан зардлыг нөхөн төлнө.

¹⁷ хог хаягдлыг ялган, зориулалтын саванд цуглуулан, тусгайлан тоноглогдсон тээврийн хэрэгслээр зөөж тогтоосон цэгт хаях;

¹⁸ газрын хэвлийд учирсан хохирлыг байгаль орчинд учирсан хохирлыг тооцох аргачлалаар тооцсон хохирлын хэмжээг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр;

- хөрсөнд учирсан хохирол, байгаль орчныг бохирдуулснаас үүсэх хохирлыг байгаль орчинд учирсан хохирлыг тооцох аргачлалаар тооцсон хохирлын хэмжээг гурав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр;

- усны нөөцөд учирсан хохирлыг тухайн сав газрын усны экологи-эдийн засгийн үнэлгээг гурав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр;

- газарт учирсан хохирлыг тухайн ангиллын газрын экологи-эдийн засгийн үнэлгээг гурав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр.

- ✓ Цэцэг сумын Баян-Овоо багийн нутаг Мянган угалзтайн нурууны байгалийн цогцолборт газрын хязгаарлалтын бүс нутагт хамраагддаг тус газарт хувиараа ашигт малтмал олборлогч иргэд 2009 оноос хойш гянтболд олборлож байсан бөгөөд 2015 онд “Ашид Алтай Майнинг” ХХК, 2016-2018 онуудад “Өгөөжтэй өв” ХХК аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 82, 2017 оны 60 дугаар тогтоолуудын дагуу нөхөн сэргээлт хийх нэрээр олборлолт явуулж эвдрэлд оруулсан. Анх 13 га талбайд нөхөн сэргээлт хийх гэрээ байгуулан ажиллаж байсан боловч 41 га болж нэмэгдсэн байна. Дээрх аж ахуйн нэгж байгууллагуудын хууль бус олборлолтоос ашигт малтмал угаах тоног төхөөрөмж суурилуулан усан сан үүссэн, томоохон хэмжээний ухагдсан нүх үүссэн, овоолго шороо ихтэй, тухайн эвдэрсэн талбайд ургамалжилт байхгүй болсон байна. Хууль бус олборлолтын улмаас байгаль орчинд учруулсан хохирлын экологи эдийн засгийн үнэлгээ хийж буруутай этгээдээр төлүүлээгүй ус ашигласны төлбөр, хогны хураамжийн төлбөрийг тооцож төсөвт төвлөрүүлсэн баримт байхгүй байна.



Мэргэжлийн байгууллагуудын хяналт шалгалтаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

3.6 Аймгийн Засаг даргын удирдамжаар 2017-2019 онуудад мэргэжлийн баг байгаль хамгаалах тухай хуулийн 26-р зүйлийн 26.1¹⁹-дэх заалт, бичил уул уурхайгаар ашигт малтмал олборлох журмын 6-р зүйлийн 6.1.1²⁰ дэх заалт, 9-р зүйлийн 9.1.4²¹ дах заалтын хэрэгжилтийг хангаж бичил уул уурхай эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүд, хувиараа ашигт малтмал олборлож буй иргэдийн үйл ажиллагаанд удаа дараа хяналт шалгалт хийснээр хууль бус олборлолт одоогоор зогссон боловч олборлолтын дараах үйл ажиллагаанд тавих хяналт сул байна. Тухайлбал:

- ✓ *Олборлолт явуулсан талбайд хүн, мал унаж гэмтэхээс хамгаалсан хаалт тавьж, тэмдэг тэмдэглэгээ байршуулаагүй*
- ✓ *Бичил уурхайн талбайд үер, усны аюулаас урьдчилан сэргийлэх ус зайлуулах суваг, шуудуу гаргаагүй*
- ✓ *Бичил уурхайн талбайд аюулгүй ажиллагааны анхааруулах самбар, тэмдэг, тэмдэглэгээ байрлуулаагүй*

3.7 Байгалийн ашигт малтмал олборлох орлогоос байгаль хамгаалах зардалд болон хууль бус олборлолт хийж хөндөгдсөн газрын нөхөн сэргээлт хийхэд орон нутгийн төсөвт хөрөнгө баталж зарцуулаагүй байна. Төсөл хөтөлбөр, Төрийн бус байгууллагуудын санаачилгаар хууль бус олборлолтоос үүссэн 362.74 га эвдэрсэн газар байгаагаас 56.72 га газар техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийсэн

¹⁹ Байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээхэд тавих хяналтыг мэргэжлийн хяналтын байгууллага хэрэгжүүлнэ.

²⁰ бичил уурхайгаар ашигт малтмал олборлох иргэдийг бүртгэж үнэмлэх олгох, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулах;

²¹ бичил уурхайн ажилтнууд, нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагын ажилтанд бичил уурхайтай холбогдсон хууль тогтоомж, хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдал болон байгаль орчны нөхөн сэргээлтийн талаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, сургалт зохион байгуулах;

байна. Эвдэрсэн газрын биологийн болон техникийн нөхөн сэргээлт хийсэн газрын хүснэгтээр харуулбал:

/Хүснэгт-5

Хууль бусаар олборлолт хийсэн эвдэрсэн газарт ТББ-ийн хийсэн нөхөн сэргээлт					
№	Сумын нэр	хийсэн газрын нэр	Нөхөн сэргээлт хийсэн ААНБ-ын нэр	Он	Нөхөн сэргээлт хийсэн талбай /техник, биологи/-н хэмжээ га
1	Алтай	Хавтаг Халтар уул	“Алтайн хөгжил- иргэдийн оролцоо” ТББ	2015	11 га техник болон биологийн нөхөн сэргээлт
2	Булган	Цоохор нуур	Увш хааны үрс” ТББ		4 га техник болон биологийн нөхөн сэргээлт
3	Үенч	Цагаан чулуут	“Үенч алтан нутаг” ТББ		12 га техник болон биологийн нөхөн сэргээлт
4	Алтай	Халтар уул	“Алтайн хөгжилд иргэдийн оролцоо” ТББ	2016	3 га техникийн болон биологийн нөхөн сэргээлт
5	Булган	Доод нарийн	“Увш хааны үрс” ТББ		5 га техник болон биологийн нөхөн сэргээлт
6	Үенч	Цахир дэвсэг	“Үенч алтан нутаг” ТББ		5 га техник болон биологийн нөхөн сэргээлт
7	Цэцэг	Хүрэн толгой	“Тажилгат Баян-Өндөр” ТББ		5 га техник болон биологийн нөхөн сэргээлт
8	Эрдэнэбүрэн	Цутгалан, Овоот	“Агт майнниг” ХХК		22 сот техникийн нөхөн сэргээлт
9	Алтай	Тамт	“Бодонч нуггийн хишиг” нөхөрлөл	2017	5 га техникийн болон биологийн нөхөн сэргээлт
10	Дөргөн	Хөх эргийн аараг	“Блю гоулд” ХХК	2018	3,5 га техникийн нөхөн сэргээлт.
11	Алтай	Тамт	“Түлхэц хад” нөхөрлөл		3 га
Нийт					56.72 га

Хүснэгтээс харахад нөхөн сэргээлт хийсэн аж ахуйн нэгж байгууллагын хувьд “Блю гоулд” ХХК нь нөхөн сэргээлтийн мэргэжлийн байгууллага, “Агт Маннинг” ХХК бизнесийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бусад нь бичил уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар зохион байгуулалтад орсон нөхөрлөл, Төрийн бус байгууллагууд бөгөөд 2015-2018 онуудад нийт 56.72²² га талбайд нөхөн сэргээлт хийсэн харагдаж байна.

3.8 Орон нутгийн бичил уул уурхай эрхэлж байгаа нөхөрлөлүүдийн гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн ашигласан болон зөвшөөрөлгүй олборлосон байгалийн баялаг болон зөвшөөрсөн хэмжээнээс хэтрүүлэн хаясан хог хаягдал байгаа эсэхэд хяналт хийж төлбөр торгууль ноогдуулсан тайлан мэдээ байхгүй байгаа нь Байгаль хамгаалах тухай хуулийн 27-р зүйлийн 27.2²³, 6²⁴-р заалтын хэрэгжилт хангалтгүй байна. Тухайлбал

- ✓ Бичил уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа Бодонч их бүрд нөхөрлөл бичил уурхайн зориулалтын талбайд хамаарахгүй газар олборлолт хийсэн байхад мэргэжлийн байгууллагын дүгнэлт гараагүй хохирлыг тооцож барагдуулаагүй
- ✓ Бодогч их бүрд нөхөрлөл нь ашигт малтмал олборлохдоо 3500 см3 хүртэлх багтаамжтай дотоод шаталтат хөдөлгүүр бүхий 2-оос илүүгүй механизмыг

²² Засаг даргын 2018 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн А/323 дугаар захирамж гарч эвдэрсэн газрын тооллого хийсэн тайлан

²³ хяналтад шаардагдах мэдээ, баримтыг холбогдох иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаар гаргуулах;

²⁴ байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянах явцдаа тухайн иргэний болон тээврийн хэрэгслийн баримт бичгийг шалгах, зөрчил илэрсэн тохиолдолд баримт бичиг, хууль бусаар агнасан, түүсэн, бэлтгэсэн, олборлосон байгалийн баялаг, ашигласан техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг хураах;

ашиглах журмаа зөрчин илүү хүчин чадалтай механизм ашиглаж байгаад дүгнэлт гаргаж шийдвэрлээгүй

- ✓ *Нөхөн сэргээлт хийлгэж, нөхөн сэргээлт хийсэн талбайг комисс томилон хүлээж авах, энэ талаарх тайланг аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлээгүй*
- ✓ *Тухайн нутаг дэвсгэрийн Засаг даргаас тогтоож өгсөн талбайд амьдрах суурьшлын талбайд суурьшиж байгаа эсэх, хог хаягдлын цэг байгуулж хог хаягдлын төлбөр төлсөн эсэхэд хяналт хийгээгүй*
- ✓ *Бичил уул уурхай эрхлэгч үйл ажиллагаанаас олсон орлогоос хуульд заасны дагуу татвар төлсөн эсэхэд хяналт хийж баримтжуулаагүй*

3.9 Бичил уул уурхайгаар ашигт малтмал олборлох журмын 3-р зүйлийн 3.2.4²⁵-р заалт, 3.2.7²⁶-р заалтын хэрэгжилтийг хангуулж олборлолт хийж байгаа нөхөрлөлүүдийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагаанд хийсэн хөдөлмөр хамгааллын хяналт, тэсэлгээний ажлыг тэсэлгээний ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлсэн гэрээний дагуу хяналт хийсэн тайлан, мэдээ байхгүй байна. Тухайлбал:

- ✓ *Бичил уурхай эрхлэгч этгээд нь тухайн жилийн үйл ажиллагааны тайланг сумын Засаг даргад хүргүүлээгүй*
- ✓ *Усан сан, ус хураагуурууд болон суваг шуудуу нь хүн, мал унаж, живж осолдохоос сэргийлсэн хаалт, хашлага, анхааруулах, хориглох тэмдэг тавиагүй*
- ✓ *Ашигт малтмалын нөөц бүхий газарт овоолго байгуулахыг хориглосон байхад их хэмжээний шороон овоолго үүссэн*
- ✓ *Тэсэлгээний ажлыг тэсэлгээний ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдээр гүйцэтгүүлсэн тайлан, гэрээ байхгүй байна.*

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- ***Бичил уул уурхайн талаар засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдсан ажил хэрэгжсэн боловч бичил уурхай эрхлэгчид байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд хамрагдаж менежмент төлөвлөгөө батлуулаагүй байна.***
- ***Эвдэрсэн газрыг нөхөн сэргээхэд шаардлагатай зардлыг холбогдох хуулийн дагуу төлөвлөж, төсөвт тусгаагүйгээс эвдэрсэн газруудыг нөхөн сэргээх, орчныг хамгаалах ажлууд хангалтгүй байна.***
- ***Мэргэжлийн байгууллагуудын хяналт, шалгалтын үйл ажиллагаа үр нөлөөтэй хэрэгжихгүй байгаагаас хууль бус олборлолтоос үүссэн эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, экологи эдийн засгийн үнэлгээ хийгдээгүй байна.***

Аудитаар байгаль орчинд нөлөөлж буй сөрөг нөлөөллийг бууруулах 12 зөвлөмж бичигдлээ.

²⁵ бичил уурхайн аюулгүй байдлын дүрмийг дагаж мөрдөх;

²⁶ тэсэлгээний ажлыг тэсэлгээний ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдээр гүйцэтгүүлэх;

Аудитын дүнд илэрсэн зөрчилд үндэслэн дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна.

ЗӨВЛӨМЖ:

Аймгийн ИТХ-ын дарга Г.Пүрэвганди-д

- Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах зардлыг МУ-ын Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулиар тогтоосон хувь хэмжээгээр төлөвлөж, санхүүжүүлэх төсөв батлах, зарцуулалтад хяналт тавих

Аймгийн Засаг дарга Б.Дүгэржав-т:

- Уул уурхай хариуцсан төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллагууд, мэргэжлийн байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулах ажлыг зохион байгуулах.
- Хувиараа, хууль бусаар алт олборлогчдын үйл ажиллагааг таслан зогсоох арга хэмжээг хууль, хяналт, хүчний байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх, сүйтгэгдсэн талбайн байгаль орчинд учруулсан хохирлыг буруутай этгээдээр төлүүлж нөхөн сэргээх ажлыг гүйцэтгүүлэх

Аймгийн Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлогын хэлтсийн дарга Б.Баярсүх-д

- Аймгийн хэмжээнд тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуй нэгж байгууллагуудын үйл ажиллагааны талаар нэгдсэн мэдээллийн санг шинэчлэх, тэдгээрийн байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөө болон орчны хяналтын хөтөлбөрийн төлөвлөгөө, гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах ажлыг зохион байгуулах.
- Уул уурхайн олборлолтын улмаас эвдэрсэн талбайг нөхөн сэргээх арга хэмжээ авах, нөхөн сэргээх зардлыг холбогдох хуульд заасан хувь хэмжээгээр төлөвлөж төсөв батлуулах санал ИТХ-д оруулах

Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга П.Эрдэнэчулуун-д

- Бичил уурхайн үйл ажиллагаа эрхэлж буй хуулийн этгээдүүдийн байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах, илэрсэн зөрчлийг арилгуулах үүргийг сумдын байгаль орчны хяналтын улсын байцаагч нарт өгч, биелэлтэд хяналт тавьж ажиллах.
- Хууль бусаар алт олборлож буй иргэд, аж ахуйн нэгжүүдийн байгальд учруулсан хохирлыг тооцож экологи эдийн засгийн үнэлгээ хийх арга хэмжээ авч холбогдох дээд байгууллагад уламжлах, хяналт шалгалтын үр нөлөөг дээшлүүлэх.

Аймгийн Байгаль орчин аялал, жуулчлалын газрын дарга Л.Батбаяр-т

- Аймгийн хэмжээнд олборлолтын үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж, нөхөрлөлүүдийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн төлөвлөгөө тайлан, ажлын төлөвлөгөө, тайланг бүрэн хүлээн авч дүгнэж байх.

- Аймгийн хэмжээнд уурхайн үйл ажиллагаа явуулахаар байгаль хамгаалах ажлын төлөвлөгөө батлуулсан хуулийн этгээдүүдийн судалгааг сумдаас авч нэгтгэх, тэдгээрийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж, сумдын байгаль орчны мэргэжилтнүүдийг нэгдсэн арга зүйгээр хангаж ажлын хариуцлагыг дээшлүүлэх.

Сумдын ИТХ, Засаг дарга нарт:

- Хууль, журамд заасны дагуу нөхөн сэргээлтийн барьцааны тусгай дансыг төрийн сан банканд байршуулж, төвлөрсөн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, холбогдох байгууллагад үнэн зөвөөр тайлагнаж байх.
- Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуй нэгжүүдийн байгаль хамгаалах, нөхөн сэргээх ажлын төлөвлөгөө, гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулж олборлолтын ажилд өртөгдсөн талбайн нөхөн сэргээлтийг актаар баталгаажуулан хүлээн авч баримтжуулж байх
- Сумдын байгаль орчны улсын байцаагч, байгаль хамгаалагчдыг холбогдох байгууллагатай ажлын уялдаа холбоотой ажиллуулж, хууль бусаар олборлолт явуулах эрсдэлтэй газруудыг тогтоож байнгын хяналт шалгалтыг хийж төлбөр хураамжийг тооцож төсөвт төвлөрүүлэх, хууль бус үйлдлийг холбогдох байгууллагуудаар шийдвэрлүүлэх

ТАЙЛАНТАЙ ТАНИЛЦСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Х.БОЛДБААТАР

ТАЙЛАН ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР:

А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАН БИЧСЭН:

АУДИТОР

Д.ЭРДЭНЭЦЭЦЭГ

